



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Даланжаргалан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/16/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Сайншанд сум 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Аудитор: Б.Алтанзул Утас: 70523020 Цахим хаяг: altanzulb@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021.02.23 № 1-6/88
танай _____ -ны № _____ -т

ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Б.ОЮУНБЯМБА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Даланжаргалан сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Даланжаргалан сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлсний орлого 0.4 сая төгрөгийг аймгийн Түрээсийн орлогын дансанд төвлөрүүлээгүй байна. Энэ нь "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хууль, "Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам"-ын 3.10-т "Түрээслүүлэгч түрээсийн орлогын 50 хувийг байгууллагын нэмэлт орлогын дансанд, 50 хувийг сар бүр аймгийн Түрээсийн орлогын 100060000953 тоот дансанд төвлөрүүлж, улирал бүр тооцоо нийлж байна" гэж заасныг зөрчсөн байна.
2. Бэлэн мөнгөөр иргэн аж ахуй нэгжээс 11.1 сая төгрөгийн хандивын орлогыг хүлээн авсан байна. Энэ нь "Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах журам"-ын 2.3-т "Мөнгөн хэлбэрээр үзүүлэх хүмүүнлэгийн тусламжийг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэлийн Онцгой байдлын байгууллагын Төрийн сан дахь нэмэлт дансанд төвлөрүүлэн авч, бүртгэнэ", "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай" хуулийн 17.1-д "Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн тусалцааг авах, хүсэхийг хориглоно" гэж заасныг зөрчсөн байна.
3. Бэлэн мөнгөөр иргэн аж ахуй нэгжээс хүлээн авсан 11.1 сая төгрөгийн хандивын орлогыг Төрийн сангийн бүртгэлийн дансанд тушаагаагүй байна. Энэ нь "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 2.6-д "Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг / түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй / ажлын

010000700

- дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана" гэж заасныг зөрчсөн байна.
4. Бэлэн мөнгөөр иргэн аж ахуй нэгжээс хүлээн авсан 11.1 сая төгрөгийн хандивын орлогыг Санхүүгийн тайланд тусгаагүй байна. Энэ нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.5 "Нягтлан бодох бүртгэлд бүх орлогыг заавал бүртгэнэ" гэж заасныг зөрчсөн байна.
 5. Бэлэн мөнгөөр иргэн аж ахуй нэгжээс хүлээн авсан 11.1 сая төгрөгийн хандивын орлогыг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр зарцуулсан байна. Энэ нь "Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах журам"-ын 4.6-д "Хүмүүнлэгийн тусламжийн мөнгөн хөрөнгийг зарцуулах хуваарилалтыг Улсын болон аймаг, нийслэлийн Онцгой комиссын хурлын шийдвэрийг үндэслэн тухайн шатны Онцгой комиссын дарга батална" гэж заасныг зөрчсөн байна.
 6. Нийт ажиллагчдын цалингаас 0.4 сая төгрөгийн чөлөөлөгдөхөөр заасан хураамжийг суутгасан байна. Энэ нь "Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 211-р тогтоолтой нийцэхгүй байна.
 7. Тайлант хугацаанд хийгдсэн 0.4 сая төгрөгийг зардлын гүйлгээг цахим төлбөрийн баримтгүйгээр /и-баримтын системд бүртгүүлээгүй/ хийсэн байна. "Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай" хууль, "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хууль, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар"-тай нийцэхгүй байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг буруу илэрхийллийн түвшнийг 7.0 сая төгрөгөөр тогтоосон. Аудитаар нийт илэрсэн алдаа, зөрчил нь тогтоосон материаллаг буруу илэрхийллийн түвшнээс 38.7 сая төгрөгөөр давсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	240.9	136.1
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,462.6	2,529.5
Нийт хөрөнгийн дүн	2,703.6	2,665.6
Нийт өр төлбөрийн дүн	162.8	11.4
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,540.8	2,654.2
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,703.6	2,665.6
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	1,489.3	860.0
Үйл ажиллагааны зардлын дүн	592.2	645.4
Үйл ажиллагааны үр дүн	897.1	214.6
Үйл ажиллагааны бус үр дүн	-113.7	-101.2
Үйл ажиллагааны нийт үр дүн	783.4	113.5
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	739.1	584.5
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	517.3	574.7
Үйл ажиллагааны ЦМГ	-	-
Хөрөнгө оруулалтын ЦМГ	220.9	9.8
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,702.1	2,540.8
Тайлант оны үр дүн	676.9	113.5
Эцсийн үлдэгдэл	2,540.8	2,654.2
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	439.5	400.0
Урсгал зардал	439.5	400.0
Хөрөнгийн зардал	-	-
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	439.5	400.0
Орон нутгийн төсвөөс санхүүжих	438.3	398.9
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	1.2	1.1

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Даланжаргалан сумын Засаг даргын тамгын газрын эрхэм зорилго:

Сумынхаа иргэдэд төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай, соёлтой хүргэх өндөр боловсролтой, мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан, чадварлаг бүтэцтэй төрийн захиргааны шилдэг байгууллага байх.

Зорилт:

- 1.Орон нутгийн захиргааны байгууллагын бодлого, шийдвэр, удирдлага, зохион байгуулалтаар хангаж, үйл ажиллагааны ил тод байдал, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх замаар иргэн бүрт хүрсэн шуурхай үйлчилгээг бий болгох
- 2.Хүний хөгжлийг дэмжсэн улс орон нутгийн бодлого зорилтыг хэрэгжүүлж, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх замаар хүний хөгжлийг бүх талаар дэмжих
- 3.Сумын хөгжлийн хэтийн бодлогыг оновчтой төлөвлөн хэрэгжүүлж, эдийн засаг, дэд бүтцийн зохистой харьцааг бий болгох замаар орон нутгийн хөгжлийг хангах
- 4.Байгаль экологийн тэнцвэрт байдлыг ханган хөдөө аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлэх замаар иргэдийн амьдрах эрүүл аюулгүй орчинг бүрдүүлэх
- 5.Авлигын эсрэг хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, ГХУС тухай хуулийн хэрэгжилтийг хангах төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг хангах

Даланжаргалан сумын Засаг даргын тамгын газар нь дараах чиг үүргийг хэрэгжүүлдэг. Үүнд:

- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги төлөвлөлт, хөтөлбөр, төслийг боловсруулах;
- Засаг даргын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах;
- Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах;
- Хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж үр дүнг тооцох;
- Тамгын газрын бичиг хэргийг хөтлөх, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;
- Төрийн захиргааны ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах;
- Тухайн шатны Хурлын хэвийн үйл ажиллагааг ханган үйлчлэх;

Гурав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системд өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 54.3 сая төгрөгийн 9 тушаалыг, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 30.0 сая төгрөгийн 1 орлогыг гүйлгээ, 30.9 сая төгрөгийн 3 зарлагын гүйлгээг шилэн дансны системд мэдээлээгүй байна.

Дөрөв. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Тав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 48.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2.7 сая төгрөгийн алдааг залруулж, 0.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 44.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 0.7 сая төгрөгийн алдаа зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

Залруулсан алдаа

Машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, програм хангамжийн дансанд нийт 2.7 сая төгрөгийн элэгдлийг дутуу тооцсоныг залруулав.

Төлбөрийн акт

Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлсний орлого 0,4 сая төгрөгийг аймгийн Түрээсийн орлогын дансанд төвлөрүүлээгүй байна. Энэ нь “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хууль, “Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам”-ын 3.10-т “Түрээслүүлэгч түрээсийн орлогын 50 хувийг байгууллагын нэмэлт орлогын дансанд, 50 хувийг сар бүр аймгийн Түрээсийн орлогын 100060000953 тоот дансанд төвлөрүүлж, улирал бүр тооцоо нийлж байна” гэж заасныг зөрчсөн байна.

Албан шаардлага

1. Бэлэн мөнгөөр иргэн аж ахуй нэгжээс 11.1 сая төгрөгийн хандивын орлогыг хүлээн авсан байна. Энэ нь “Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах журам”-ын 2.3-т “Мөнгөн хэлбэрээр үзүүлэх хүмүүнлэгийн тусламжийг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэлийн Онцгой байдлын байгууллагын Төрийн сан дахь нэмэлт дансанд төвлөрүүлэн авч, бүртгэнэ”, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 17.1-д “Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглоно” гэж заасныг зөрчсөн байна.
2. Бэлэн мөнгөөр иргэн аж ахуй нэгжээс хүлээн авсан 11.1 сая төгрөгийн хандивын орлогыг Төрийн сангийн бүртгэлийн дансанд тушаагаагүй байна. Энэ нь “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 2.6-д “Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг / түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй / ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана” гэж заасныг зөрчсөн байна.
3. Бэлэн мөнгөөр иргэн аж ахуй нэгжээс хүлээн авсан 11.1 сая төгрөгийн хандивын орлогыг Санхүүгийн тайланд тусгаагүй байна. Энэ нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.5 “Нягтлан бодох бүртгэлд бүх орлогыг заавал бүртгэнэ” гэж заасныг зөрчсөн байна.
4. Бэлэн мөнгөөр иргэн аж ахуй нэгжээс хүлээн авсан 11.1 сая төгрөгийн хандивын орлогыг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр зарцуулсан байна. Энэ нь “Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах журам”-ын 4.6-д “Хүмүүнлэгийн тусламжийн мөнгөн хөрөнгийг зарцуулах хуваарилалтыг Улсын болон аймаг, нийслэлийн Онцгой комиссын хурлын шийдвэрийг үндэслэн тухайн шатны Онцгой комиссын дарга батална” гэж заасныг зөрчсөн байна.
5. Шилэн дансны системд Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 121.9 сая төгрөгийн 10 зарлагын гүйлгээг, 88.9 сая төгрөгийн 1 орлогын гүйлгээг мэдээлээгүй байна. Энэ нь “ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ” хуулийн 6.4.5-т “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрээр долоо хоногийн дотор мэдээлнэ” гэж заасныг зөрчсөн байна.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаатай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Тайлант онд мал амьтадын бүртгэлд хурга, төлөг, нийт 12 толгой малыг нас дэвшүүлж бүртгээгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалыг санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдлөг болгож, малын нас дэвшилтийг бүрэн бүртгэж, мал амьтдын тайланг үнэн зөв гаргаж байх.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаатай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 122.7 сая төгрөгийн 153 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь “ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ” хуулийн 31.1-т “Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно” гэж заасантай нийцэхгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг акталж данснаас хасах, эсхүл дахин шинээр үнэ тогтоож, ашиглалтын байдлыг тодорхой болгох

3. Зардлын данстай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: Нийт ажиллагчдын цалингаас 0.4 сая төгрөгийн чөлөөлөгдөхөөр заасан хураамжийг суутгасан байна. Энэ нь “КОРОНАВИРУС ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЦАР ТАХЛЫН ҮЕД АЙЛ ӨРХ, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ” Засгийн газрын 211-р тогтоолтой нийцэхгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Тайлант онд ажиллагчдын цалингаас суутгасан хог хаягдлын хураамжийг тухайн өрхийн дараа оны төлбөрт шилжүүлэн тооцуулах

4. Худалдан авалттай холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт: Тайлант хугацаанд хийгдсэн 0.4 сая төгрөгийг зардлын гүйлгээг цахим төлбөрийн баримтгүйгээр /и-баримтын системд бүртгүүлээгүй/ хийсэн байна.

4.2 Өгсөн зөвлөмж: “НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ” хууль, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТУХАЙ” хууль, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын холбогдох заалтуудыг хэрэгжүүлж, гүйлгээ хийхдээ и-баримтын бүрдлийг хангаж ажиллах

6.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
НИЙТ									

6.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	11	48.4	1	2.7	1	0.4	4	44.6	4	0.7
	НИЙТ	11	48.4	1	2.7	1	0.4	4	44.6	4	0.7